# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1998 оны 8 дугаар сарын 21 өдөр | Дугаар А/180 | Улаанбаатар хот

**Компаниудын дүрэм батлаж, захирлуудыг томилох тухай**

Нэг. " Хот тохижилт" компаний бүтцийн өөрчлөлт хийсэнтэй холбогдуулан шинээр байгуулагдаж байгаа "Улаанбаатар-Зам засвар", "Нөөц", "Гэрэлтүүлэг чимэглэл", "Цэцэрлэгжилт" компаниудын дүрмийг 1,2,3,4 дүгээр хавсралтаар тус тус батлсугай.

Хоёр. Өлзий-Утасын Магсаржавыг "Цэцэрлэгжилт", Шаравдоржийн Төмөрбаатарыг "Гэрэлтүүлэг чимэглэл", Бадмаараагийн Отгонсүрэнг "Улаанбаатар-Зам засвар", Должингийн Пүрэвсүрэнг "Нөөц" компаний захирлаар 1998 оны 8 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн тус тус ажиллуулсугай.

Гурав. Комисс байгуулж, компаниудын актыг 8 дугаар сарын 20-ны дотор хүлээлцүүлэхийг хотын Ерөнхий менежер /Н.Гомбожав/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ Ж.НАРАНЦАЦРАЛТ

Нийслэлийн Засаг даргын 1998 оны
А/180 тоот захирамжийн
1 дүгээр хавсралт

# "УЛААНБААТАР-ЗАМ-ЗАСВАР" КОМПАНИ (УҮГ)-ИЙН ДҮРЭМ

Хуулийн этгээд болох "Улаанбаатар-зам засвар" компани (УҮГ)-нь Монгол Улсын нөхөрлөл, компанийн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, бусад хууль тогтоомжийн дагуу төрийн өмчид үндэслэн байгуулагдсан аж ахуйн тооцоот улсын үйлдвэрийн газар (УҮГ) хэлбэрээр ажиллана.

## НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

**Компанийн (УҮГ) нэр, байршил**

1-1 Компани нь Улаанбаатар зам засвар гэж нэрлэгдэх бөгөөд захиргаа нь нийслэл хотод байрлана.

1-2 Компанийн албан ёсны байршил нь Нийслэлийн Баянзүрх дүүргийн 16-р хорооны нутаг дэвсгэрт байрлана.

## ХОЕРДГААР ЗҮЙЛ

**Компанийн (УҮГ) эрх зүйн байдал.**

2-1 "Улаанбаатар -зам засвар" компанийг үүсгэн байгуулагч нь Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Улаанбаатар хотын захирагч түүний ажлын алба байна.

2-2 Компани нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчимаар ажиллахаас гадна Нийслэлийн захиалагаар үйл ажиллагаагаа явуулж , бие даан иргэний харилцаанд ордог хуулийн этгээдийн эрх зүйн байдалтай улсын үйлдвэрийн газар юм.

## ГУРАВДУГААР ЗҮЙЛ

**Компанийн (УҮГ) үйл ажиллагааны зорилго чиглэл;**

Компанийн доор дурдсан үйлдвэрлэл үйлчилгээ явуулна.

3-1 Хотын замын угсралт, засвар хийх

3-2 Хотын болон албан байгууллагын захиалгатай ажил хийх

3-3 Замын тохижилтын ажилд шаардлагатай хавтан бродюр, тумбэ (шон) замын лентэн брусс зэрэг хийц бүтээгдэхүүн үйлдвэрлэх.

3-4 Гүүр, зам далан сувгийн жижиг засвар, явган хүний зам гүүр, гарц гаргах, авто машины зогсоол хийх, цас, мөсний халтиргаа гулгаа арилгах, шороон зам тэгшлэх.

3-5 Үйлдвэрлэл үйлчилгээний ажилтай холбогдсон тоног төхөөрөмж, түүхий эд сэлбэг материал олж авах зорилгоор гадаад,дотоод худалдаа эрхлэх.

3-6 Үйлдвэр,үйлчилгээний төрлийг шинээр нэмэгдүүлэх буюу эсвэл татан буулгах,өөрчлөх тухай бүрд бүртгэлийн байгууллагад мэдэгдэх бөгөөд тусгай зөвшөөрөл шаардагдах ажил үйлчилгээ эрхлэх бол эрх бүхий байгууллагын албан ёсны зөвшөөрөл авна.

3-7 Туслах аж ахуй эрхлэх.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ.

Компанийн(УҮГ) эрх хэмжээ

4-1 Компанийг нийслэлийн Засаг даргын шийдвэр гарсан өдрөөс байгуулагдсанд тооцох бөгөөд нөхөрлөл , компанийн тухай хуулинд заасан журмаар улсын бүртгэлд бүртгүүлж,хуулийн этгээдийн эрхтэй болно,

4-2 Компани нь гадаад дотоодын байгууллагатай үндсэн ажил үүргийнхээ дагуу иргэний гүйлгээнд оролцох хотын зам засвар,тохжилтонд шаардагдах түүхий эд сэлбэг хэрэгсэл ,материалыг гадаад ,дотоод зах зээлээс бие дааж бэлтгэх.

4-3 Компани нь өөрийн тамга,тэмдэг, бичгийн хэвлэмэл хуудастай байна.

4-4 Компани нь үндсэн үүргээ хэрэгжүүлэхийн тулд зам,гүүр,талбайн засвар авто хэсэг зэрэг аж ахуйн дотоод тооцоотой нэгжүүд байгуулан ажиллуулж болно.

4-5 Компани нь эд хөрөнгийн дараах эрх үүрэгтэй.

а) өөртөө олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж компанийн дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж,ашиглах.

б) үндсэн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжинд заасан эрх хэмжээнийхээ дотор захиран зарцуулах.

в) улсын төсөв болоод нийслэлийн захиалгаар хийлгэх тохижилтын ажлын хөрөнгийг хууль тогтоомж, зардал, зөвшөөрлийн дагуу зарцуулж тайлагнана.

г) ажил үйлдвэрлэл үйлчилгээ явуулсаны үр дүнд олсон ашгийг дээд байгууллагаас тогтоосон нормативт хэмжээгээр зориулалтын дагуу захиран зарцуулах.

д) үндсэн хөрөнгөнд хамаарах эд хөрөнгө олж авах, төрийн өмчийн этгээдэд эзэмшүүлэх, ашиглах, шилжүүлэх болон худалдах, хувьчлах ажилд төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулинд заасан журмыг баримтлана.

ТАВДУГААР ЗҮЙЛ:

Дүрмийн сангийн хэмжээ

5-1 Компанийн дүрмийн сангийн хэмжээ нь нийт.............сая төгрөг байна. Үүнээс:

а) Үндсэн хөрөнгө
Үүнээс барилга байгууламж.................сая
Тоног төхөөрөмж..................................сая
б) Эргэлтийн хөрөнгө нь.......................сая
Үүнээс бичт хөрөнгө..............................сая
5-2 Дүрмийн санг холбогдох хуулийн дагуу өөрчилж болно.

ЗУРГАДУГААР ЗҮЙЛ.

Удирдлага

6-1 Компанийн(УҮГ)өдөр тутмын үйл ажиллагааг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн томилсон гүйцэтгэх захирал удирдана.

6-2 Улаанбаатар хотын захирагч, Захирагчийн ажлын албаны дарга бөгөөд ерөнхий менежертэй хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллана.

6-3 Захирал нь Улаанбаатар хотын захирагч, Захирагчийн ажлын албаны дарга бөгөөд ерөнхий менежер, Хот тохижилтын хэлтсийн өмнө ажлаа хариуцаж тайлагнана.

6-4 Захирал нь инженер техникийн ажилтан, удирдах хүмүүсийг оруулсан зөвлөл байгуулан ажиллаж болно.

6-5 Компаний захирал дараах эрх үүрэгтэй.

1) Компанийн итгэмжлэхгүйгээр төлөөлөх, итгэмжлэх олгох.

2) Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжинд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах.

3) Үйлдвэр санхүүгийн төлөвлөгөө боловсруулж Захирагчийн ажлын албаны дарга бөгөөд ерөнхий менежерээр батлуулж ажиллах.

4) Захиргааны бүтцийг боловсруулж хотын ерөнхий менежерээр батлуулах,

Улаанбаатар хотын захирагчийн албанаас тогтоосон албан тушаалын бүдүүвч, цалингийн сангийн хэмжээнд багтаан ажилтанг томилох, чөлөөлөх, цалин хөлсийг тогтоох, хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллах.

5) Үйлдвэрлэл худалдаа, технологийн нууцат хамаарах мэдээллийг тогтоох.

6) Хөдөлмөрийн хууль тогтоомжинд нийцсэн байгууллагын дотоод журмыг баталж мөрдүүлэх.

7) Хуулийн дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах.

8) Улсаас тогтоосноос бусад бүтээгдэхүүн ажил үйлчилгээнд шинээр үнэ тариф тогтоож мөрдүүлэх.

9) Маргаантай асуудлаар компанийг төлөөлж нэхэмжлэл гаргах.

10) Эрх хэмжээний асуудлаар компанийн хэмжээнд даган мөрдөх тушаал заавар гаргах.

11) Ажлын шаардлагаар комисс, зөвлөл байгуулах, татан буулгах.

12) Хууль тогтоомжинд заасан бусад эрх, үүргийг хүлээнэ.

6–6. Захирал нь хувийн эрх ашгийн үүднээс компанийн нэрийг ашиглаж бусадтай гэрээ хэлцэл хийх, компанийн өмч эд хөрөнгөөр бусад аж ахуйн нэгж, байгууллага, санд хандив өргөх, зээл өгөх, зээлийн баталгаа гаргахыг хориглоно.

6–7. Захи рал нь бусад хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргаанд буюу нам төрийнбус шашны байгууллагын, сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

6–8. Захирлын буруутай үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомж, энэ дүрэм Захирагчийн ажлын албаны дарга бөгөөд ерөнхий менежертэй байгуулсан гэрээнд заасан эрхээ хэтрүүлэх буюу урвуулан ашигласнаас учирсан хохирлыг хууль тогтоомжинд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

Мөн гэрээ биелүүлээгүй, ажлын хариуцлага алдсан тохиолдолд компанийн захирлаас чөлөөлөх хүртэл арга хэмжээ авагдана.

6–9. Захи рал нь хот нийтийн эзэмшлийн зам угсралт, засвар тохижилтын ажлын талаар компаниас хоттой байгуулсан гэрээний эцсийн үр дүн, чанарын асуудлыг Улаанбаатар хотын захирагч, Захирагчийн ажлын алба, Хот тохижилтын хэлтсийн өмнө шууд хариуцна. Компанийн зүгээс ашиглалтын гэрээний заалтыг биелүүлээгүй, биелэлт хангалтгүй тохиолдолд Улаанбаатар хотын захирагч, Захирагчийн ажлын алба, Хот тохижилтын хэлтсийн саналын дагуу компанийн захирлыг өөрчлөх арга хэмжээ авна.

## ДОЛООДУГААР ЗҮЙЛ.

Санхүү бүртгэл хяналтын систем.

7–1. Санхүү бүртгэлийн систем нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу явагдана.

7–2. Санхүүгийн жил нь шинэ оны 1 дүгээр сарын 1–нээс эхэлж 12 дугаар сарын 31–нээр дуусна. Санхүүгийн жил нь байгуулагдсан өдрөөс эхлэх бөгөөд санхүүгийн сүүлчийн жил нь татан буугдсан өдрөөр дуусгавар болно.

7–3. Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар, бусад хураамжийг төлнө.

7–4. Анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтөлж, тайлан тэнцлийг улирлаар гаргаж Татварын алба, санхүүгийн байгууллага, Захирагчийн ажлын албаны Хот тохижилтын хэлтэст тушаана.

7–5. Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцно.

7–6. Компанийн нягтлан бодогчийг Сангийн яам, Хотын захирагчийн ажлын албатай зөвшилцөн компанийн захирал томилно.

НАЙМДУГААР ЗҮЙЛ.

"Улаанбаатар–зам–засвар" компанийг үүсгэн байгуулагчийн бүрэн эрх:

8–1. Тус компанийг (УҮГ) үүсгэн байгуулагч нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Улаанбаатар хотын захирагч, түүний ажлын алба байх бөгөөд хуулинд заасан эрх эдэлнэ.

8–2. "Улаанбаатар–зам–засвар" компани (УҮГ) нь Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, түүний Хот тохижилтын хэлтсийн удирдлагад үйл ажиллагаа явуулна.

8–3. Нийслэлийн Өмчийн газар нь төрийн болон орон нутгийн өмчийн төлөөллийн үүднээс заасан эрх хэмжээнийхээ хүрээнд компанийг удирдана.

8–4. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон Өмчийн газар үүсгэн байгуулагчаас шилжүүлсэн доорхи бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1). Компанийн жилийн болон хэтийн төлөвлөгөө, төсөв, жилийн тайлан тэнцлийг хянаж батлах.

2) Хот нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хянах.

3)Компанийн харъялах эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тооцоо, гаргах ажлыг зохион байгуулж, удирдах төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтанд хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх.

4) Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөгөө, ашиг орлогын хуваарилалт, цалин хөлсний норм нормативыг холбогдох байгууллагатай тохиролцож тогтоох.

5) Өгсөн захиалгын үндсэн дээр хот тохижилтын байгууллагыг шаардлагат хөрөнгөөр хангах.

6) Төрийн болон нийслэлийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөнд хамаарах хөрөнгийг данснаас хасах, шинээр үндсэн хөрөнгө бүрдүүлэх санал захиалгыг хянаж батлах шийдвэр гаргуулах.

7) Компанийн (УҮГ) захирлыг томилох, чөлөөлөх санал тавьж захиралтай холбогдох хуулинд заасан нөхцлийг хангасан болон үйл ажиллагааных нь онцлогийг харгалзан тус гасан тодорхой нөхцөлтэй гэрээ байгуулах, өмч хөрөнгийг захиран зарцуулах талаарх түүний эрх хэмжээг тогтооно.

8) "Улаанбаатар–зам–засвар" компани (УҮГ)–ийг татан буулгах, өөрчлөн байгуулах тухай санал боловсруулж тавих.

9) Компанийн дотоод дүрэмд өөрчлөлт оруулах санал тавих.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

9–1. Компанийг татан буулгах шийдвэрийг үүсгэн байгуулагчийн шийдвэрээр болон хуульд заасан үндэслэлээр гаргаж болно.

9–2. Компанийг татан буулгах тохиолдолд үүсгэн байгуулагчаас томилсон комисс татан буулгах ажлыг эрхэлнэ.

9–3. Татан буулгах комисс нь дуусталтын тайлан баланс гаргаж үүсгэн байгуулагчид танилцуулна.

9–4. Компанийг татан буулгах тохиолдолд нийтэд мэдээлж, өр төлбөр авлагыг хуульд заасан дараалал, журмын дагуу барагдуулсаны дараа үүсгэн байгуулагчид шилжүүлнэ.

АРАВДУГААР ЗҮЙЛ

10–1. Энэхүү дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

10–2. Энэхүү дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт нь компанийн дүрмийн салшгүй хэсэг болно.

АРВАННЭГДҮГЭЭР ЗҮЙЛ.

11–1. Монгол улсын Нөхөрлөл, компани, улсын үйлдвэрийн газрын тухай хуульд заасан эрхээ хэтрүүлсэн буюу үүргээ биелүүлээгүй нөхцөлд хууль тогтоомжийн дагуу төр захиргаа, хуулийн байгууллагын өмнө компани хариуцлага хүлээнэ.

11–2. "Улаанбаатар–зам–засвар" компани нь зөвхөн өөрийн мэдэлд байгаа хууль тогтоомжинд заасан ёсоор төлбөр гаргуулж болох хөрөнгийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

Нийслэлийн Засаг даргын 1996 оны 1.22 дугаар захирамжаар хүчингүй

Нийслэлийн Засаг даргын 9/180
тоот захирамжийн хоёрдугаар
хавсралт.

# "НӨӨЦ" КОМПАНИ (УҮГ)–ИЙН ДҮРЭМ

Хуулийн этгээд болох "Нөөц" компани (УҮГ) нь Монгол улсын нөхөрлөл, компаний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, бусад хууль тогтоомжийн дагуу төрийн өмчид үндэслэн байгуулагдсан аж ахуйн тооцоот улсын үйлдвэрийн газар (УҮГ) хэлбэрээр ажиллана.

Нэгдүгээр зүйл:

Компанийн (УҮГ) нэр, байршил:

1.1. Компани нь "Нөөц" гэж нэрлэгдэх бөгөөд захиргаа нь нийслэл хотод байрлана.

1.2. Компаний албан ёсны байршил нь нийслэлийн Хан-Уул дүүргийн III хорооны нутаг дэвсгэрт байрлана.

Хоёрдугаар зүйл:

2.1. "Нөөц" компанийг үүсгэн байгуулагч нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Улаанбаатар хотын Захирагч, түүний ажлын алба байна.

2.2. Компани нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллахаас гадна нийслэлийн захиалгаар үйл ажиллагаагаа явуулж, бие даан иргэний харилцаанд ордог хуулийн этгээдийн эрх зүйн байдалтай улсын үйлдвэрийн газар юм.

Гуравдугаар зүйл.

Компаний (УҮГ) үйл ажиллагааны зорилго чиглэл:

3.1. Хогийн төвлөрсөн цэгүүдэд буулгасан хотын хог хаягдлыг дарж устгах, хөрсийг эрүүлжүүлэх, эрүүл ахуй, ариун цэврийн дэг журмыг сахиулах, халдваргүйжүүлэх,

3.2. Төвлөрсөн цэгүүдээс хоёрдогч түүхий эд ялгаж бэлтгэх

3.3. Хотын золбин нохой, муур устгаж мах, арьсыг нь зохих технологийн дагуу боловсруулж ашиглах, экспортлох,

3.4. Үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтай холбогдсон тоног төхөөрөмж, түүхий эд, сэлбэг материал гадаад зах зээлээс олж авах зорилгоор гадаад худалдаа эрхлэх,

3.5. Үйлдвэрлэл, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, эсвэл зогсоож өөрчлөхөд тухай бүр улсын бүртгэлийн байгууллагуудад мэдэгдэх, тусгай зөвшөөрөл шаардагдах ажил үйлчилгээ эрхлэх бол албан ёсны зөвшөөрөл авах,

Дөрөвдүгээр зүйл:

4.1. Компанийг нийслэлийн Засаг даргын шийдвэр гарсан өдрөөс байгуулагдсанд тооцох бөгөөд нөхөрлөл, компаний тухай хуулинд заасан журмаар улсын бүртгэлд бүртгүүлж, хуулийн этгээдийн эрхтэй болно.

4.2. Компани нь үндсэн чиглэлийнхээ дагуу үйл ажиллагаа явуулахад шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгслэл, түүхий эд материалын хангалтын асуудлыг шийдэхдээ гадаад, дотоодын байгууллагуудтай эрх зүйн харьцаанд орж бие даан гэрээ, хэлэлцээр байгуулж ажиллана.

4.3. Компани өөрийн тамга, тэмдэг, бичгийн хэвлэмэл хуудастай байна.

4.4. Компани нь үндсэн үүргээ хэрэгжүүлэхийн тулд туслах үйлдвэрлэл цехийн байж болох бөгөөд цехүүдийг аж ахуйн тооцоотой ажиллуулж болно.

4.5. Компани эд хөрөнгийн дараах эрх үүрэгтэй

а/ өөртөө олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж компанийн дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах,

б/ үндсэн хөрөнгийн холбогдох хууль тогтоомжинд заасан эрх хэмжээнийхээ дотор захиран зарцуулах,

в/ улсын төсөв болоод нийслэлийн захиалгаар хийлгэх тохижилтын ажлын хөрөнгийг хууль тогтоомж, зардал зөвшөөрлийн дагуу зарцуулж тайлагнана.

г/ ажил үйлдвэрлэл үйлчилгээ явуулсаны үр дүнд олсон ашгийг дээд байгууллагаас тогтоосон норматив хэмжээгээр өөрөө мэдэж дүрмийнхээ зориулалтын дагуу захиран зарцуулах,

д/ үндсэн хөрөнгөнд хамаарах эд хөрөнгө олж авах, төрийн өмчийн этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, шилжүүлэх болон худалдах, хувьчлах ажилд төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулинд заасан журмыг баримтлана.

Тавдугаар зүйл.

Дүрмийн сангийн хэмжээ:

5.1. Компанийн дүрмийн сангийн хэмжээ нь нийт ...........сая төгрөг байна. Үүнээс:

а/Үндсэн хөрөнгө

| | |
|---|---|
| Үүнээс барилга байгууламж | сая |
| Тоног төхөөрөмж | сая |
| б/ Эргэлтийн хөрөнгө | сая |
| Үүнээс биет хөрөнгө | сая |
| Биет бус хөрөнгө | сая |

5.2 Дүрмийн санг холбогдох хуулийн дагуу өөрчилж болно.

Зургадугаар зүйл.

6.1 Компанийн /УҮГ/ өдөр тутамын үйл ажиллагааг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн томилсон захирал удирдана.

6.2 Улаанбаатар хотын захирагч болон Захирагчийн ажлын албаны дарга бөгөөд ерөнхий менежер хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллана.

6.3 Захирал нь Улаанбаатар хотын захирагч, Захирагчийн ажлын албаны дарга бөгөөд ерөнхий менежер, хот тохижилтын хэлтсийн өмнө ажлаа хариуцаж тайлагнана.

6.4 Захирал нь инженер техникийн ажилтан, удирдах хүмүүсийг оруулсан зөвлөл байгуулан ажиллаж болно.

6.5 Компанийн захирал дараах эрх үүрэгтэй.

1/ Компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх, итгэмжлэх олгох.

2/ Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжинд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах.

3/ Үйлдвэр санхүүгийн төлөвлөгөө боловсруулж захирагчийн ажлын албаны дарга бөгөөд ерөнхий менежерээр батлуулж ажиллах.

4/ Захиргааны бүтцийг боловсруулж хотын ерөнхий менежерээр батлуулах, Улаанбаатар хотын захирагчийн албанаас тогтоосон албан тушаалын бүдүүвч, цалингийн сангийн хэмжээнд багтаан ажилтан томилох, чөлөөлөх, цалин хөлсийг тогтоох хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллах.

5/ Үйлдвэрлэл худалдаа, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох.

6/ Хөдөлмөрийн хууль тогтоомжинд нийцсэн байгууллагын дотоод журмыг баталж мөрдүүлэх.

7/ Хуулийн дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах.

8/ Улсаас тогтоосоноос бусад бүтээгдэхүүн ажил үйлчилгээнд шинээр үнэ тариф тогтоож мөрдүүлэх.

9/ Маргаантай асуудлаар компанийг төлөөлж нэхэмжлэл гаргах.

10/ Эрх хэмжээний асуудлаар компанийн хэмжээнд даган мөрдөх тушаал заавар гаргах.

11/ Ажлын шаардлагаар комисс, зөвлөл байгуулах, татан буулгах.

12/ Хууль тогтоомжинд заасан бусад эрх, үүргийг хүлээнэ.

6.6 Захирал нь хувийн эрх ашгийн үүднээс компанийн нэрийг ашиглаж бусадтай гэрээ хэлцэл хийх, компанийн өмч эд хөрөнгөөр бусад аж ахуйн нэгж, байгууллага, санд хандив өргөх, зээл өгөх, зээлийн баталгаа гаргахыг хориглоно.

6.7 Захирал нь бусад хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргаанд буюу нам төрийн бус шашны байгууллагын, сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

6.8. Захирлын буруутай үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомж, энэ дүрэм Захирагчийн ажлын албаны дарга бөгөөд ерөнхий менежертэй байгуулсан гэрээнд заасан эрхээ хэтрүүлэх буюу урвуулан ашигласнаас учирсан хохирлыг хууль тогтоомжинд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

Мөн гэрээ биелүүлээгүй, ажлын хариуцлага алдсан тохиолдолд компаний захирлаас өөрчлөх хүртэл арга хэмжээ авагдана.

Долдугаар зүйл.

Санхүү бүртгэл хяналтын систем:

7.1. Санхүү бүртгэлийн систем нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу явагдана.

7.2. Санхүүгийн жил нь шинэ оны 1–р сарын 1–нээс эхлэж 12–р сарын 31–нээр дуусна. Санхүүгийн жил нь байгуулагдсан өдрөөс эхлэх бөгөөд санхүүгийн сүүлчийн жил нь татан буугдсан өдрөөр дуусгавар болно.

7.3. Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар бусад хураамжийг төлнө.

7.4. Анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтөлж, тайлан тэнцлийг улирлаар гаргаж, татварын алба, санхүүгийн байгууллага, Захирагчийн ажлын албаны Хот тохижилтын хэлтэст тушаана.

7.5. Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийг тооцно.

7.6. Компанийн нягтлан бодогчийг Сангийн яам, хотын Захирагчийн ажлын албатай зөвшилцөн компаний захирал томилно.

Наймдугаар зүйл.

Компанийг үүсгэн байгуулагчийн бүрэн эрх:

8.1. "Нөөц" (УҮГ) компанийг үүсгэн байгуулагч нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Улаанбаатар хотын захирагч түүний ажлын алба байх бөгөөд хуульнд заасан эрх эдэлнэ.

8.2. "Нөөц" компани (УҮГ) нь Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, түүний хот тохижилтын хэлтсийн удирдлагаанд үйл ажиллагаа явуулна.

8.3. Нийслэлийн өмчийн газар нь төрийн болон орон нутгийн өмчийн төлөөллийн үүднээс заасан эрх хэмжээнийхээ хүрээнд компанийг удирдана.

8.4. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон Өмчийн газар үүсгэн байгуулагчаас шилжүүлсэн доорхи бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1/компаний жилийн болон хэтийн төлөвлөгөө, төсөв, жилийн тайлан тэнцлийг хянаж батлах

2/ хот нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлыйг зохион байгуулж, гүйцэтгэлийг хянах,

3/ компанийн харъяалагдах эд хөрөнгийн анхан шатны бүртгэл тооллого, тайлан тооцоо, гаргах ажлыг зохион байгуулж, удирдах төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтанд хяналт тавьж түүний үр ашгийг дээшлүүлэх

4/ төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдэд дагаж мөрдөх төлөвлөгөө, ашиг орлогын хуваарилалт, цалин хөлсний норм нормативыг холбогдох байгууллагатай тохиролцож тогтоох,

5/ өгсөн захиалгын үндсэн дээр хот тохижилтын байгууллагыг шаардлагат хөрөнгөөр ханагах

6/ төрийн болон нийслэлийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөнд хамаарах хөрөнгийг дансаас хасах, шинээр үндсэн хөрөнгө бүрдүүлэх санал захиалгыг хянаж батлах шийдвэр гаргуулах,

7/ компаний (УҮГ) захирлыг томилох, чөлөөлөх санал тавьж захиралтай холбогдох хуульнд заасан нөхцлийг хангасан болон үйл

ажиллагааных нь онцлогийг харгалзан тусгасан тодорхой нөхцөлтэй гэрээ байгуулах, өмч хөрөнгийг захиран зарцуулах талаарх түүний эрх хэмжээг тогтооно.

8/"Нөөц" компани (УҮГ) –ийг татан буулгах, өөрчлөн байгуулах тухай санал боловсруулж тавих,

9/ компаний дотоод дүрэмд өөрчлөлт оруулах санал тавих

Есдүгээр зүйл.

9.1. Компанийг татан буулгах шийдвэрийг үүсгэн байгуулагчийн шийдвэрээр болон хуульд заасан үндэслэлээр гаргаж болно.

9.2. Компанийг татан буулгах тохиолдолд үүсгэн байгуулагчаас томилсон комисс татан буулгах ажлыг эрхлэнэ.

9.3. Татан буулгах комисс нь дуусгалтын тайлан баланс гаргаж үүсгэн байгуулагчид танилцуулна.

9.4. Компанийг татан буулгах тохиолдолд нийтэд мэдээлж, өр төлбөр авлагыг хуульд заасан дараалал, журмын дагуу барагдуулсаны дараа үүсгэн байгуулагчид шилжүүлнэ.

Аравдугаар зүйл.

10.1. Энэхүү дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт нь компаний дүрмийн салшгүй хэсэг болно.

Арваннэгдүгээр зүйл:

11.1. Монгол улсын нөхөрлөл, компани, УҮГ–ын тухай хуульд заасан эрхээ хэтрүүлсэн буюу үүргээ биелүүлээгүй нөхцөлд хууль тогтоомжийн дагуу төр захиргаа , хуулийн байгууллагын өмнө компани хариуцлага хүлээнэ.

11.2. "Нөөц" компани нь зөвхөн өөрийн мэдэлд байгаа хууль тогтоомжид заасан ёсоор төлбөр гаргуулж болох хөрөнгийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

—o O o—

Нийслэлийн Засаг даргын 2001 оны 40 дугаар захирамжаар хүчингүй

Нийслэлийн Засаг даргын 1998 оны
17/180 тоот захирамжийн
3 дугаар хавсралт

# "ХОТ ЦЭЦЭРЛЭГЖИЛТ" КОМПАНИ (УҮГ)-ИЙН ДҮРЭМ

Хуулийн этгээд болох Хот цэцэрлэгжилт компани (УҮГ) нь Монгол улсын Нөхөрлөл, компаний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан аж ахуйн тооцоот улсын үйлдвэрийн газар (УҮГ) хэлбэрээр ажилана.

Нэг. Компаний нэр, байршил:

1. Компани нь "Хот цэцэрлэгжилт" гэж нэрлэгдэх бөгөөд захиргаа нь нийслэл хотод байрлана.

2. Компанийн албан ёсны байршил нь нийслэлийн Баянзүрх дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт оршино.

Хоёр. Компаний эрх зүйн байдал.

1. "Хот цэцэрлэгжилт" компанийг үүсгэн байгуулагч нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Улаанбаатар хотын захирагч байна.

2.Компани нь өөрт оногдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллахаас гадна нийслэлийн захиалгаар үйл ажиллагаагаа явуулж, бие даан иргэний харилцаанд ордог хуулийн этгээдийн эрх зүйн байдалтай улсын үйлдвэрийн газар юм.

Гурав. Компаний үйл ажиллагааны зорилго чиглэл.

1. "Хот цэцэрлэгжилт" компаний үндсэн зорилго нь нийслэл хотын нийтийн эзэмшлийн гудамж, талбайг цэцэрлэгжүүлэх, арчлан хамгаалах ажлыг хариуцан гүйцэтгэхэд оршино. Компани нь дор дурьдсан үйл ажиллагаагаа явуулна. Үүнд:

а) Нийтийн эзэмшлийн гудамж цэцэрлэгүүдийн мод, сөөг, зүлэгт талбайг арчлан хамгаалах, хотод шинээр мод, сөөг, цэцэг зүлэг тарих.

б) Мод, сөөг, нэг болон олон наст цэцэг үржүүлэх, өөрийн болон хот,аж ахуйн нэгж, иргэдэд худалдан борлуулах мод, сөөг, зүлэг, цэцгийн үр төүх, боловсруулах.

в) Нийслэл, аж ахуйн нэгж, иргэдийн захиалгаар цэцэрлэгжүүлэх ажлыг хийхээс гадна үйлдвэрлэл, гадаад дотоод худалдаа, зуучлал, импорт экспорт, реэкспорт зэрэг үйл ажиллагаа явуулна.

Дөрөв. Компаний эрх

1. Компанийг Нийслэлийн Засаг даргын шийдвэр гарсан өдрөөс байгуулагдсанд тооцох бөгөөд Нөхөрлөл компаний тухай хуулинд заасан журмаар улсын бүртгэлд бүртгүүлж, хуулийн этгээдийн эрхтэй болно.

2. Компани нь гадаад дотоодын байгууллагатай ажил үүргийн дагуу эрх зүйн харилцаанд орж (гадаад дотоод худалдаа зуучлал, импорт экспорт) хотын цэцэрлэгжүүлэлтийн ажилд шаардагдах үр суулгац, багаж хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж зэргийг гадаад дотоодын зах зээлээс бэлтгэж нийлүүлнэ.

3. Компани нь өөрийн тамга тэмдэг, бичгийн хэвлэмэл хуудастай байна.

4. Компани нь үндсэн үүргээ хэрэгжүүлэхийн тулд цэцэрлэгжүүлэх аж ахуй, цэцгийн аж ахуй, мод үржүүлэх аж ахуй, авто хэсэг, механик цех зэрэг аж ахуйтай байж болох бөгөөд үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр шинэ аж ахуй байгуулан ажиллуулж болно.

5. Компани эд хөрөнгийн дараах эрх үүрэгтэй.

а) Өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, компаний дүрэмд заасан үйл ажиллагааны дагуу эзэмшиж ашиглах.

б) Үндсэн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжинд заасан эрх хэмжээнийхээ дотор захиран зарцуулах.

в) Улсын төсөв болоод нийслэлийн захиалгаар хийгдэх цэцэрлэгжилтийн ажлын хөрөнгийг хууль тогтоомж, зардал зөвшөөрлийн дагуу зарцуулж тайлагнах.

г) Ажил үйлдвэрлэл үйлчилгээ явуулсаны үр дүнд олсон ашгийг дээд байгууллагаас тогтоосон норматив хэмжээгээр өөрөө захиран зарцуулах.

д) Үндсэн хөрөнгөнд хамаарах эд хөрөнгө авах, төрийн өмчийн этгээдэд шилжүүлэх, ашиглуулах, шилжүүлэх болон худалдах, хувьчлах ажилд төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулинд заасан журмыг баримтлах.

Тав. Дүрмийн сангийн хэмжээ

1. Компаний дүрмийн сангийн хэмжээ нь хуучин ажиллаж байсан "Цэцэрлэгжилт" компаний дүрмийн сангийн хэмжээнд байх бөгөөд үүнээс:

а) Үндсэн хөрөнгө 29013947 сая төгрөг

б) Эргэлтийн хөрөнгө 13432703 сая төгрөг байна.

2. Дүрмийн санг холбогдох хуулийн дагуу өөрчилж болно.

Зургаа. Удирдлага.

1. Компаний үйл ажиллагааг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн томилсон захирал удирдана.

2. Захирал Улаанбаатар хотын захирагч болон Захирагчийн ажлын албаны дарга бөгөөд ерөнхий менежертэй хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллана.

3. Захирал нь Улаанбаатар хотын захирагч, ерөнхий менхежер, Хот тохижилтын хэлтсийн даргын өмнө ажлаа хариуцаж тайлагнана.

4. Захирал нь компаний удирдах хүмүүс, инженер техникийн ажилтан нарыг оруулсан зөвлөл байгуулан ажиллаж болно.

5. Компаний захирал нь дараах эрх үүрэгтэй.

а) Компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх, итгэмжлэх олгох.

б) Эд хөрөнгийн холбогдох хууль тогтоомжинд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах.

в) Үйлдвэр санхүүгийн төлөвлөгөө боловсруулж Захирагчийн ажлын албаны дарга бөгөөд ерөнхий менежерээр батлуулан ажиллах.

г) Захиргааны бүтцийг боловсруулан батлуулах. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас тогтоосон орон тоо, цалингийн сангийн хэмжээнд багтаан ажилтанг томилох, чөлөөлөх, цалин хөлсийг тогтоож ажилтан ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах.

д) Үйлдвэрлэл, худалдаа, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох.

е) Хөдөлмөрийн хууль тогтоомжинд нийцсэн байгууллагын дотоод журмыг баталж мөрдүүлэх.

ё) Хуулийн дагуу анхан шатны бүртгэлийг хөтлөж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах.

ж) Улсаас тогтоосноос бусад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд шинээр үнэ тариф тогтоож мөрдүүлэх.

з) Маргаантай асуудлаар компанийг төлөөлж нэхэмжлэл гаргах.

и) Эрх хэмжээний хүрээнд компанийн хэмжээнд дагаж мөрдөх тушаал, заавар гаргах.

к) Ажлын шаардлагаар комисс, зөвлөл байгуулах, татан буулгах.

л) Хууль тогтоомжинд заасан бусад эрх үүргийг хүлээх.

6. Захирал нь хувийн эрх ашгийн үүднээс компанийн нэрийг ашиглаж бусадтай гэрээ хэлцэл хийх, компанийн эд хөрөнгөөр бусад аж ахуйн нэгж, байгууллага, санд хандив өргөх, зээл өгөх, зээлийн баталгаа гаргахыг хориглоно.

7. Захирал нь бусад хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргаанд буюу нам төрийн бус шашны байгууллага сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

8. Захирлын буруутай үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомж, энэ дүрэм Захирагчийн ажлын албаны дарга бөгөөд ерөнхий менежертэй байгуулсан гэрээний эрхээ хэтрүүлэх буюу урвуулан ашигласнаас учирсан хохирлыг өөрийн хувийн эд хөрөнгөөр хариуцах ба хууль тогтоомжинд заасны дагуу захиргааны болон хуулийн хариуцлага хүлээнэ. Мөн гэрээ биелүүлээгүй ажлын хариуцлага алдсан тохиолдолд компанийн захирлаас өөрчлөх хүртэл арга хэмжээ авна.

Долоо. Санхүү бүртгэл хяналтын систем.

1. Санхүүгийн бүртгэлийн систем Монгол улсын хууль тогтоомжийн дагуу явагдана.

2. Санхүүгийн ажил нь байгуулагдсан өдрөөс эхлэн санхүүгийн сүүлчийн жил нь татан буугдсан өдрөөр дуусгавар болно.

3.Компани нь Монгол улсын хуулийн дагуу орлогын болон бусад татвар хураамжийг төлнө.

4.Анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтөлж, тайлан тэнцлийг улирлаар гаргаж татварын алба, санхүүгийн байгууллага, Захирагчийн ажлын албаны Хот тохижилтын хэлтэст тушаана.

5. Компани Монгол улсын хууль тогтоомжийн дагуу үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлыг тооцно.

Найм. "Хот цэцэрлэгжилт" компанийн үүсгэн байгуулагчийн бүрэн эрх:

1. "Хот цэцэрлэгжилт" компанийн үүсгэн байгуулагч нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Улаанбаатар хотын захирагч байх бөгөөд хуулинд заасан эрх эдлэнэ.

2. "Хот цэцэрлэгжилт" компани нь Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, түүний Хот тохижилтын хэлтсийн удирдлагаар үйл ажиллагаагаа явуулна.

3. Нийслэлийн Өмчийн газар нь төрийн болон орон нутгийн өмчийн төлөөлөлийн үүднээс заасан эрх хэмжээний хүрээнд компанийг удирдана.

4. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон Өмчийн газар үүсгэн байгуулагчаас шилжүүлсэн доорхи бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

а) Компаний жилийн болон хэтийн төлөвлөгөө, төсөв,жилийн тайлан тэнцлийг хянаж батлах.

б) Хот нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн эзэмшил, хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлийг хянах.

в) Компаний харъяалах эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тооцоо гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтанд хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх.

г) Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөгөө, ашиг орлогын хуваарилалт, цалин хөлсний норм нормативыг холбогдох байгууллагатай тохиролцож тогтоох.

д) Өгсөн захиалгын үндсэн дээр цэцэрлэгжүүлэх байгууллагыг шаардлагатай хөрөнгөөр хангах.

е) Төрийн болон нийслэлийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөнд хамаарах хөрөнгийг данснаас хасах, шинээр үндсэн хөрөнгө бүрдүүлэх санал захиалгыг хянаж батлах ба шийдвэр гаргуулах.

ё) Компаний захирлыг томилох, чөлөөлөх санал тавьж, захиралтай холбогдох хуулинд заасан нөхцлийг хангасан болон үйл ажиллагааны онцлогийг харгалзан тусгасан тодорхой нөхцөлтэй гэрээ байгуулах, өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар түүний эрх хэмжээг тогтоох.

ж) "Хот цэцэрлэгжилт" компанийг татан буулгах, өөрчлөн байгуулах тухай санал боловсруулах, компаний дотоод дүрэмд өөрчлөлт оруулах санал тавих.

Ес. Татан буулгах.

9.1. Компанийг татан буулгах шийдвэрийг үүсгэн байгуулагчийн шийдвэрээр болон хуульд заасан үндэслэлээр гаргаж болно.

9.2. Компанийг татан буулгах тохиолдолд үүсгэн байгуулагчаас томилсон комисс татан буулгах ажлыг эрхлэнэ.

9.3. Татан буулгах комисс нь дуусгалтын тайлан баланс гаргаж үүсгэн байгуулагчид танилцуулна.

9.4. Компанийг татан буулгах тохиолдолд нийтэд мэдээлж, өр төлбөр, авлагыг хуульд заасан дараалал, журмын дагуу барагдуулсаны дараа үүсгэн байгуулагчид шилжүүлнэ.

Аравдугаар зүйл.

10.1. Энэхүү дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийн тухай бүр эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

10.2. Энэхүү дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт нь компаний дүрмийн салшгүй хэсэг болно.

Арваннэгдүгээр зүйл. Компаний хүлээх хариуцлага.

11.1. Монгол улсын Нөхөрлөл, компаний тухай хуульд заасан эрхээ хэтрүүлсэн буюу үүргээ биелүүлээгүй нөхцөлд хууль тогтоомжийн дагуу төр захиргаа, хуулийн байгууллагын өмнө компани хариуцлага хүлээнэ.

11.2. "Хот цэцэрлэгжилт" компани нь зөвхөн өөрийн мэдэлд байгаа хууль тогтоомжинд заасан ёсоор төлбөр гаргуулж болох хөрөнгийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

———oOo———

Нийслэлийн Засаг даргын 2001 оны 34 дүгээр захирамжаар хүчингүй

Нийслэлийн Засаг даргын 21/280
тоот захирамжийн дөрөвдүгээр
хавсралт.

**"ГЭРЭЛТҮҮЛЭГ ЧИМЭГЛЭЛ" КОМПАНИ (УҮГ)-ИЙН ДҮРЭМ**

Хуулийн этгээд болох "Гэрэлтүүлэг чимэглэл" компани (УҮГ) нь Монгол улсын нөхөрлөл компаний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, бусад хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан аж ахуйн тооцоот улсын үйлдвэрийн газар (УҮГ) хэлбэрээр ажиллана.

**Нэгдүгээр зүйл. Компаний нэр байршил:**

1.1. Компани нь "Гэрэлтүүлэг чимэглэл" гэж нэрлэгдэх бөгөөд захиргаа нь нийслэл хотод байрлана.

1.2 Компаний албан байршил нь нийслэлийн Баян зүрх дүүргийн .......дугаар хорооны нутаг дэвсгэрт оршино.

**Хоёрдугаар зүйл. Компаний эрх зүйн байдал**

2.1 "Гэрэлтүүлэг чимэглэл" компаний үүсгэн байгуулагч нь Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Улаанбаатар хотын захирагч байна.

2.2 Компани нь өөрт оногдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллахаас гадна нийслэлийн захиалгаар үйл ажиллагаа явуулж бие даан иргэний харилцаанд ордог хуулийн этгээдийн эрх зүйн байдалтай улсын үйлдвэрийн газар юм.

**Гуравдугаар зүйл. Компаний үйл ажиллагааны зорилго, чиглэл**

3.1 "Гэрэлтүүлэг чимэглэл" компаний үндсэн зорилго нь нийслэл хотын хот нийтийн эзэмшлийн гудамж талбайн гадна гэрэлтүүлэгийн инженерийн шугам сүлжээний ашиглалтын найдвартай ажиллагааг хангах, хамгаалах, хотын болон байгууллагын мэдлийн гадна реклам чимэглэлийн засвар үйлчилгээг захилга, гэрээний дагуу чанартай хийж гүйцэтгэхэд оршино.

Компани нь доор дурьдсан үйл ажиллагаа явуулана. Үүнд:

а/ Нийтийн эзэмшлийн гадна гэрэлтүүлгийн шугам сүлжээний ашиглалт хамгаалалт урсгал засварын ажлыг хариуцан гүйцэтгэх:

б/ Гэрэлтүүлгийн сүлжээнд их засвар, хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудыг мэргэжлийн бусад байгууллагуудтай тэгш эрхтэйгээр тендерт оролцож хийх:

в/ Хотын мэдлийн гадна реклам, чимэглэлүүдийн засвар үйлчилгээг гэрээний дагуу хариуцаж шинээр хийгдэх реклам чимэглэлийн ажлыг тендерт оролцох болон захиалгын журмаар хийх:

г/ Нийслэл Улаанбаатар хотын дэвсгэрийн болон бусад газрын байгууллага аж ахуйн нэгжүүдийн захиалагаар цахилгаан угсралтын болон реклам чимэглэлийн ажлыг хийх, дотоод худалдааны чиглэлийн үйл ажиллагааг явуулана.

Дөрөвдүгээр зүйл. Компаний эрх хэмжээ

4.1 Компанийг Нийслэлийн засаг даргын шийдвэр гарсан өдрөөс байгуулагдсанд тооцох бөгөөд Нөхөрлөл, компаний тухай хуулинд заасан журмаар улсын бүртгэлд бүртгүүлж хуулийн этгээдийн эрхтэй болно.

4.2 Компани нь байгууллага аж ахуйн нэгжтэй үндсэн чиглэлийн дагуу үйл ажиллагаа явуулахад шаардагдах материал тоног төхөөрөмжийн хангалтын асуудлыг шийдэхдээ бие дааж гадаад дотоодын байгууллагуудтай эрх зүйн харилцаанд орж гэрээ байгуулан ажиллах ба хот нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн шугам сүлжээ, рекламын ашиглалт засвар үйлчилгээнд зориулагдах материал эд анги, тоног төхөөрөмжийг зах зээлээс нийлүүлэхдээ Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай тохиролцоны үндсэн дээр гэрээ хэлцлийг нийлүүлэгч байгууллагатай хийх буюу хотоос энэ чиглэлээр зарласан тендерт оролцож ажиллана.

4.3. Компани нь өөрийн тамга, тэмдэг бичгийн хэвлэмэл хуудастай байна.

4.4 Компани нь үндсэн үүргээ хэрэгжүүлэхийн тулд үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр шинэ тасаг байгуулан ажиллуулж болно.

4.5 Компани эд хөрөнгийн дараах эрх үүрэгтэй:

а/өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж компаний дүрэмд заасан үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмших ашиглах,

б/үндсэн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ дотор захиран зарцуулах

в/улсын төсөв болоод нийслэлийн захиалгаар хийлгэх тохижилтын ажлын хувьд ажлын хөрөнгийг хууль тогтоомж, зардал, зөвшөөрлийн дагуу зарцуулж, тайлагнах

г/ажил үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсны үр дүнд олсон ашгийг дээд байгууллагаас тогтоосон норматив хэмжээгээр өөрөө мэдэж дүрмийнхээ зориулалтын дагуу захиран зарцуулах,

д/үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, төрийн өмчийн этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, шилжүүлэх болон худалдах, хувьчлах ажилд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулинд заасан журмыг баримтлах,

вдугаар зүйл. Дүрмийн сангийн хэмжээ:

5.1. Компаний дүрмийн сан:

| | |
|---|---|
| а/үндсэн хөрөнгө | сая.төг |
| б/эргэлтийн хөрөнгө | сая.төгрөгөөс бүрдэнэ. |

5.2. Дүрмийн санг холбогдох хуулийн дагуу өөрчилж болно.

Зургаа. Удирдлага:

6.1. Компаний үйл ажиллагааг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн томилсон захирал удирдана.

6.2. Захирал нь Улаанбаатар хотын Захирагч болон Захирагчийн ажлын албаны дарга бөгөөд Ерөнхий менежер, хот тохижилтын хэлтсийн өмнө ажлаа хариуцаж тайлагнана.

6.4. Захирал нь компаний удирдах хүмүүс, инженер техникийн ажилтнуудыг оруулсан зөвлөл байгуулан ажиллаж болно.

6.5. Компаний захирал нь дараах эрх үүрэгтэй.

а/ компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх, итгэмжлэх олгох,

б/эд хөрөнгийн холбогдох хууль тогтоомжид заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах

в/үйлдвэр, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж Захирагчийн ажлын албаны дарга бөгөөд Ерөнхий менежерээр батлуулан ажиллах

г/захиргааны бүтцийг боловсруулан хотын ерөнхий менежерээр батлуулах, Улаанбаатар хотын Захирагчийн албанаас тогтоосон албан тушаалын бүдүүвч, цалингийн сангийн хэмжээнд багтаан ажилтанг томилох, чөлөөлөх, цалин хөлсийг тогтоож ажилтан, ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах,

д/үйлдвэрлэл, худалдаа, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох,

е/хуулийн дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах,

ж/хотоос тогтоосноос бусад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд шинээр үнэ тариф тогтоож мөрдүүлэх,

з/маргаантай асуудлаар компанийг төлөөлж нэхэмжлэл гаргах,

и/ эрх хэмжээний хүрээнд компаний хэмжээнд дагаж мөрдөх тушаал, заавар гаргах

к/ажлын шаардлагаар комисс, зөвлөл байгуулах, татан буулгах,

л/хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг хүлээх,

6.6. Захирал нь хувийн эрх ашгийн үүднээс компаний нэрийг ашиглаж бусадтай гэрээ хэлцэл хийх, компаний эд хөрөнгөөр бусад аж ахуйн нэгж, байгууллага, санд хандив өргөх, зээл өгөх, зээлийн баталгаа гаргахыг хориглоно.

6.7. Захирал нь бусад хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргаанд буюу нам төрийн бус шашны байгууллагын, сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

6.8. Захирлын буруутай үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомж, энэ дүрэм, Захирагчийн ажлын албаны дарга бөгөөд Ерөнхий мене жертэй байгуулсан гэрээний эрхээ хэтрүүлэх буюу урвуулан ашигласнаас учирсан хохирлыг өөрийн хувийн эд хөрөнгөөр хариуцах ба хууль тогтоомжид заасны дагуу захиргааны болон хуулийн хариуцлага хүлээнэ. Мөн гэрээ биелүүлээгүй ажлын хариуцлага алдсан тохиолдолд компаний захирлаас өөрчлөх хүртэл арга хэмжээ авна.

9.9. Захирал нь хот нийтийн эзэмшлийн гэрэлтүүлэг, реклам чимэглэлийн талаар компаниас хоттой байгуулсан ашиглалтын гэрээний эцсийн үр дүн, чанарын асуудлыг Улаанбаатар хотын Захирагч, Захирагчийн ажлын алба, Хот тохижилтын хэлтсийн өмнө шууд хариуцна. Компаний зүгээс ашиглалтын гэрээний заалтыг биелүүлээгүй, биелэлт хангалтгүй тохиолдолд Улаанбаатар хотын Захирагч, Захирагчийн ажлын алба, Хот тохижилтын хэлтсийн саналын дагуу компаний захирлыг өөрчлөх арга хэмжээ авна.

Долдугаар зүйл. Санхүү бүртгэл хяналтын систем:

7.1. Санхүүгийн бүртгэлийн систем Монгол улсын хууль тогтоомжийн дагуу явагдана.

7.2. Санхүүгийн жил нь шинэ оны I сарын 01-нээс эхэлж 12 дугаар сарын 31-нээр дуусна. Санхүүгийн жил нь байгужулагдсан өдрөөс эхэлж санхүүгийн сүүлчийн жил нь татан буугдсан өдрөөр дуусгавар болно.

7.3. Компани Монгол улсын хуулийн дагуу орлогын болон бусад татвар хураамжийг төлнө.

7.4. Анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтөлж, тайлан тэнцлийг улирлаар гаргаж Татварын алба, Санхүүгийн байгууллага, Захирагчийн албаны Хот тохижилтын хэлтэст тушаана.

7.5. Компани Монгол улсын хууль тогтоомжийн дагуу үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлыг тооцно.

Найм. "Гэрэлтүүлэг чимэглэл" компанийг үүсгэн байгуулагчийн бүрэн эрх

8.1. "Гэрэлтүүлэг чимэглэл" компаний үүсгэн байгуулагч нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улаанбаатар хотын Захирагч байх бөгөөд хуулинд заасан эрх эдэлнэ.

8.2. "Гэрэлтүүлэг чимэглэл" компани нвь улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, түүний Хот тохижилтын хэлтсийн удирдлаганд үйл ажиллагаагаа явуулна.

8.3. Нийслэлийн өмчийн газар нь төрийн болон орон нутгийн өмчийн төлөөллийн үүднээс заасан эрх хэмжээний хүрээнд компанийг ужирдана.

8.4. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон бмчийн газар үүсгэн байгуулагчаас шилжүүлсэн доорхи бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

а/ компаний ажилтийн болон хэтийн төлөвлөгөө, төсөв, жилийн тайлан тэнцлийг хянаж батлах,

б/хот нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн эзэмшил, хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлийг хянах,

в/компаний харъяалах эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тооцоо гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтанд хяналт тавьж түүний үр ашгийг дээшлүүлэх,

г/төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөгөө, ашиг орлогын хуваарилалт, цалин хөлсний норм нормативыг холбогдох байгууллагатай тохиролцож тогтоох,

д/ өгсөн захиалгын үндсэн дээр хот тохижилтын байгууллагыг шаардлагатай хөрөнгөөр хангах,

е/төрийн болон нийслэлийн өмчид хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөнд хамаарах хөрөнгийг данснаас хасах, шинээр үндсэн хөрөнгө бүрдүүлэх санал залналгыг хянаж батлах ба шийдвэр гаргуулах,

ж/ компаний захирлыг томилох, чөлөөлөх санал тавьж захиралтай холбогдох хуулинд заасан нөхцлийг хангасан болон үйл ажиллагааны онцлогийг харгалзан тусгасан тодорхой нөхцөлтэй гэрээ байгуулах, өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар түүний эрх хэмжээг тогтоох,

з/"Гэрэлтүүлэг чимэглэл" компанийг татан буулгах, өөрчлөн байгуулах тухай санал боловсруулах, компаний дотоод дүрэмд өөрчлөлт оруулах санал тавих,

Есдүгээр зүйл. Татан буулгах:

9.1. Компанийг татан буугдах шийдвэрийг үүсгэн байгуулагчийн шийдвэрээр болон хуульд заасан үндэслэлээр гаргаж болно.

9.2. Компанийг татан буулгах тохиодолд үүсгэн байгуулагчаас томилсон комисс татан буулгах ажлыг эрхлэнэ.

9.3. Татан буулгах комисс нь дуусгалтын тайлан баланс гаргаж үүсгэн байгуулагчид танилцуулна.

9.4. Компанийг татан буулдгах тохиолдолд нийтэд мэдээлж өр төлбөр авлагыг хуульд заасан дараалал, журмын дагуу барагдуулсны дараа үүсгэн байгуулагчид шилжүүлнэ.

Аравдугаар зүйл.

10.1. Энэхүү дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

10.2. Энэхүү дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт нь компаний дүрмийн салшгүй хэсэг болно.

Арваннэгдүгээр зүйл. Компаний хүлээх хариуцлага:

11.1. Монгол улсын Нөхөрлөл компаний тухай хуульд заасан эрхээ хэтрүүлсэн буюу үүргээ биелүүлээгүй нөхцөлд хууль тогтоомжийн дагуу төр захиргаа, хуулийн байгууллагын өмнө компани хариуцлага хүлээнэ.

11.2. "Гэрэлтүүлэг чичмэглэл" компани зөвхөн өөрийн мэдэлд байгаа хууль тогтоомжид заасан ёсоор төлбөр гаргуулж болох хөрөнгийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

—o O o—